

ОХУ-ЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

*А.Нямдолжин**

Боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хүн ам зүй болон орон сууцны асуудлыг шийдэх явдал Орос улсыг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлалын нэг хэсэг, урт хугацааны чиглүүлэгч нь болж байна. Цаашдаа энэ зорилт Орос улсыг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлалын салшгүй хэсэг нь болж, урт хугацаанд үндэсний тэргүүн зэргийн зорилт байх юм. Хувь хүний өрсөлдөх чадвар, орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн нөхцөл, орон сууц, боловсрол, эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн орчин үеийн нийгмийн орчныг тухайн хүний эргэн тойронд бүрдүүлэх тухай бүхэлдээ ярих ёстой хэмээн Ерөнхий сайд В.В.Путин үзэж байна. Оросын нийгэмд тулгарч буй гурван гол асуудлыг дурдвал, нэгдүгээрт нийгмийн хөтөлбөрийг боловсруулах, тэдгээрийн үр нөлөө, явцыг үнэлэхэд иргэний нийгэм, мэргэжлийн байгууллагыг оролцуулах явдал, хоёрдугаарт нийгмийн салбарт бодит өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, гуравдугаарт нийгмийн бодлогыг инновацийн технологид ашиглах явдал юм.

Нийгэм, эдийн засгийн хөгжил нь бүтээгдэхүүн бараа үйлчилгээгээр зах зээлийг хангаж, эдийн засаг санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, энэ нь эргээд нийгэм болоод хүрээлэн байгаа орчинд тааламжтай байдлыг бий болгон үйлчлэх нөхцөл болдог. Аливаа улсын нийгэм эдийн засгийн хөгжил нь тухайн орны хүн ам зүйн бодлогоо хэрхэн боловсруулж, хэрхэн яаж хэрэгжүүлэхээс шууд шалтгаалж байна.

2010 онд орон даяар өрнөсөн амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх өргөн хүрээтэй хөтөлбөрийн үр дүнд Засгийн газрын хэд хэдэн чухал баримт бичиг батлагдан хэрэгжих шатандаа явж байна. Тухайлбал, 2020 он хүртэл хүн амын дунд архи дан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх цар хүрээг бууруулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үзэл баримтлал, 2010-2015 онд тамхины хэрэглээний эсрэг явуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх, эмнэлгийн магадлан шинжилгээний төрийн тогтолцоог хэрэгжүүлэх үзэл баримтлалууд орж байна.¹ Амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх хөтөлбөрийн үр дүнд насанд хүрэгчдэд зориулсан 502, хүүхэд өсвөр насныханд зориулсан үнэ төлбөргүй 193 эрүүл мэндийн төв нээгдэн үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр төвүүдийн гол зорилго нь хүн амын урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх явдал юм.

Хүн амын хүн ам зүйн хөгширөлт ОХУ-д дэлхийн бусад орны адилаар хурц хэвээр байна. Оросын 5 хүн тутмын нэг нь 60-аас дээш настай 30,7 сая хүн оршин сууж байна. Өндөр настай хүмүүсийн тоо

* А.Нямдолжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

эрчимтэй өсч байгаа шалтгаан нь шинээр мэндэлсэн хүүхдийн тоо буурч, хүмүүс өндөр насалж байгаатай холбоотой юм. Хүн амын дунд өндөр насны 21 сая эмэгтэй, харин эрэгтэйчүүдийн тоо гурав дахин бага буюу 8 сая хүн байгаа нь эрэгтэйчүүд тэтгэврийн насанд хүрэлгүй эрт нас барж байгаагаас ийм таагүй харьцаа бий болоод байна. Өндөр настай хүмүүс түүний дотор 80-аас дээш насны хүмүүс хүн амын хамгийн хурдан өсч байгаа бүлэг болоод байна. 1989 онд оросын хүн амын 15 орчим хувь нь өндөр настай хүн байсан бол 2008 онд 17 хувь болж нэмэгджээ. Орос улсад хөдөлмөрийн чадвартай хүн амд ноогдох хүн ам зүйн ачааллын үзүүлэлт өсч байна. Ахмад хүмүүсийн тоо ихсэх тусам төсвөөс тэтгэвэрт их мөнгө хуваарилах шаардлагатай болж байна. Хөдөлмөрийн насны хүмүүс болон тэтгэврийн насны хүмүүсийн тэнцвэргүй байдал улс орны төв хэсэгт илүүтэй ажиглагдаж байна. Росстатын дүгнэснээр 2026 онд хүн амын тоо буурсан тохиолдолд тэтгэврийн насны болон хөдөлмөрийн насны хүмүүсийн харьцаа 1:2 болно. Оросын ахмад настнууд тэтгэвэрт гарах нас нь болсон ч ажилласаар байдаг. Тэгэхлээр Орос улсад тэтгэвэрт гарсан дөрвөн хүн тутмын нэг нь буюу тэтгэврийн насны 9 сая хүн хөдөлмөрлөж байна. Сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлт ахмад настнуудын эрэлтийг нэмэгдүүлж, тэтгэврийн мөнгөнөөс дунджаар хоёр дахин их орлоготой ажлын байраар тэднийг хангаж байна. Өндөр настай хүмүүсийн олонх нь дээд боловсролтой бөгөөд талаас илүү хувь нь төв суурин газар оршин суудаг. Орос улсад шинээр мэндэлж байгаа хүүхдийн тоо нэмэгдсэн ч, ахмадуудад ноогдож байгаа ачаалал их байна.

ОХУ 2011 онд Эрүүл мэндийн байгууллагад томоохон өөрчлөлт хийхээр төлөвлөж байна. ОХУ-ын Эрүүл Мэнд Нийгмийн Хөгжлийн яамны сайд Татьяна Голиковагийн хэлж байгаагаар 2013 он гэхэд ОХУ-ын бүх эрүүл мэндийн байгууллагуудын 80% их засвар болон техникийн шинэчлэлт хийх юм байна. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог мэдээллийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн, эрүүл мэндийн картыг өөрчлөн цахим хэлбэртэй болгосноор дараалалгүйгээр үйлчлүүлэх давуу талтайн дээр энэ картаараа Оросын аль ч эмнэлэгээс үйлчилгээ авах боломжтой болох юм байна. Оросын тэтгэвэрт гарсан ахмадууд эмнэлэгт үзүүлэхээр ирэх тохиолдолд төрөөс нь 1000 рубль /45000 төг/ шууд олгож /жилд 1 удаа/, хэрэв ахмадууд эмнэлэгт хэвтэж эмчлүүлээгүй тохиолдолд дээрхи мөнгө өөрт нь олгогдох ажээ. 2010 онд баталсан “Эрүүл мэндийн зайлшгүй даатгалын тухай”, “Эм тарианы хэрэглээний тухай” хуулиуд нь эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг шатчилан өөрчилж, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг илүү өндөр, шинэ түвшинд гаргах юм.

2025 он хүртэлх ОХУ-ын хүн ам зүйн бодлогын үзэл баримтлалын эхний шат болох 2007-2010 оны зорилтыг хэрэгжүүлж дуусаад байна. 2010 онд 1 сая 789,6 мян. хүүхэд төрсөн нь 2009 оноос 27,9 мянгаар (1,6%) илүү хүүхэд мэндэлжээ. Нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь 18,3%

байна. Төрөлтийн ерөнхий коэффициент 2006 онд 1,30-аас 2010 онд 1,59 болж өссөн бол, нас баралтын коэффициент 2006 онд 15,2-оос 2010 онд 14,3 болж, 5.9%-иар буурсан байна. Төрөлт нэмэгдсэн нь засгийн газраас бага насны хүүхэдтэй гэр бүлийн материаллаг байдлыг дээшлүүлэх, төрөлтийг дэмжих нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүн юм. “Хүүхэдтэй гэр бүлийг дэмжих төрийн дэмжлэгийн нэмэлт арга хэмжээний тухай” хуулийг 2006 оны 12-р сарын 29-нд баталж, 2007 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Энэ хуулинд заасны дагуу “Эхийн капитал” хэмээх сертификатыг хоёр болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд олгох юм байна. Энэхүү капиталын хэмжээг жил бүр инфляцийн түвшинг харгалзан тогтоох бөгөөд 2007-2010 онуудад эхийн капитал 250 мянган рублиас 343,4 мянган рубль болж нэмэгджээ. Эхийн капиталыг орон сууцны нөхцөлөө сайжруулах, зээлийн орон сууцны төлбөр хийх, хүүхдийн боловсрол, эхийн нийгмийн даатгалын хуримтлал зэрэгт зарцуулж байна. Түүнчлэн олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих үүднээс сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын дунд сургуульд сурдаг хүүхдийг өглөөний цай, өдрийн хоолны үнэ төлбөргүй хөтөлбөрт хамруулах, эмчийн жороор үнэгүй эм тариа олгож байна. Олон хүүхэдтэй гэр бүлийг хүндэтгэх харьцааны уламжлалыг дэмжих, эдгээр гэр бүлийг бэхжүүлэх зорилгоор ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар “Эцэг эхийн алдар” хэмээх төрийн одонг 2008 онд бий болгон олон хүүхэдтэй болон хүүхэд үрчилж аван өсгөн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг шагнаж байхаар болсон байна. 2009-2010 онд тус одонгоор 121 мянган олон хүүхэдтэй гэр бүлүүд шагнагджээ. ОХУ-ын 66 субъектэд олон хүүхэдтэй гэр бүлийн нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор төрийн шагналууд болон медаль, диплом, хүндэт тэмдэг, хүндэт цол, мөнгөн шагнал олгодог байна. 2002-2010 онд хэрэгжүүлсэн “Орон сууц” хөтөлбөрийн “Залуу гэр бүлийг орон сууцаар хангах” дэд хөтөлбөрийн хүрээнд залуу гэр бүлийн орон сууцны нөхцлийг сайжруулах төрийн зүгээс дэмжлэг үзүүлж байна.² 2008-2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 34,5 мянган залуу гэр бүлүүд орон сууцны нөхцөлөө сайжруулсан байна. Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд тэдний амьдралын нөхцөл болоод чанарт ихээхэн нөлөөлж байна. 2010 оны 1-р сарын 1-нээс эхлэн жирэмсэн, төрсөн эхчүүд, түүнчлэн 1,5 хүртэлх насны хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. 2008 оны 1-р сарын 1-нээс эхлэн цэргийн албанд татагдсан гэр бүлд олгох 2 төрлийн тэтгэмжийг шинээр олгох болсон байна. Сар бүрийн хүүхэд асаргааны тэтгэмж анхны хүүхдэд 2106 рубль, хоёр дахь болон дараагийн хүүхдэд 3746 рубль олгож байна. Түүнчлэн хүүхэд төрүүлсэний 1 удаагийн олгодог тэтгэмж 2009 онд 9989 рубль, 2010 онд 10989 рубль, 2011 онд 11703 рубль болж нэмэгдсэн байна.

Хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах, орон сууцыг нийт хүн амд хүртээмжтэй, боломжтой болгох зорилгоор 2011-2015 онд хэрэгжүүлэх “Орон сууц” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэний үр дүнд 2015 он гэхэд 3 ам бүлтэй гэр бүлийн 4 жилийн орлогын нийлбэртэй 54 кв.м талбай бүхий орон сууцны үнэ тэнцэнэ гэж үзэж байна.

Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь өвчлөл, эндэгдлийн шалтгаанаар нь бүртгэж, хамгийн их гэснийг тэргүүлэх шалтгаан гэж үздэг. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааныг аваад үзэхэд нэгдүгээрт - цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хоёрдугаарт хавдрын өвчин, гуравдугаарт гаднын нөлөөний улмаас, үүнд амиа хорлох болон зам тээврийн осол ихэнх хувийг эзэлж байна, дөрөвдүгээрт хоол боловсруулах эрхтэний өвчин, тавдугаарт амьсгалын замын өвчин орж байна. Хоол боловсруулах эрхтэний болон амьсгалын замын өвчинөөр нас барах явдал байсаар байгаа нь хүн амын эрүүл мэндийн боловсролтой холбоотой бөгөөд өөрийн эрүүл мэндийн төлөө тавих анхаарал сул, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахгүй байгаатай холбоотой юм. 2010 оны нас баралтын үзүүлэлтээс харахад, гаднын нөлөөний улмаас нас барах явдал 8,1%-иар, зам тээврийн ослоор 3,6%-иар, архины хордлогоор 32,6%-иар, амиа хорлосоны улмаас нас барах явдал 11,3%-иар буурчээ. 1000 хүнд ноогдох нас баралтын коэффициент 2009 онд 14,2 байсан бол 2010 онд 14,3 болж 20 мянган хүнээр нэмэгдсэн байна. Үүний гол шалтгаан нь 2010 оны 7, 8-р сард болсон цаг уурын огцом өөрчлөлт болох хэт халуун сөргөөр нөлөөлсөн байна.

Эрүүлийг хамгаалах тогтолцооны ажлын үр өгөөжийг үнэлэх гол шалгуур нь эхийн болон нялхасын эндэгдэлийг бууруулах, эх хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанар гол үзүүлэлт болдог. “Төрөх сертификат” хөтөлбөр, 2006-2010 онд хэрэгжүүлсэн үндэсний тэргүүлэх “Эрүүл мэнд” төслийн үр дүнд 4 жилийн хугацаанд 2006 онтой харьцуулахад 2010 онд нялхасын эндэгдэл 26,4%-иар буурсан байна.

2007-2009 онуудад хүн амын бодит орлого 17,1%-иар өсөж, сарын дундаж цалингийн хэмжээ 26,1%-иар, тэтгэвэр тэтгэмж 37%-иар тус тус өсжээ. Хүн амын амьжиргааны түвшинээс доогуур орлоготой хүн амын тоо 2006 онд 15,2% (21,5 сая хүн) байсан бол 2009 онд 13,2% (18,5 сая хүн) болж буурсан байна.

2008 оны 12-р сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалингийн шинэ тогтолцоог нэвтрүүлж эхэлсэнээр эрүүлийг хамгаалах салбарын ажилчдын сарын дундаж цалин 2009 онтой харьцуулахад 2010 онд 8%-иар нэмэгдэж, эмчийн сарын дундаж цалин 45495,7 мянган рубль, боловсролын салбарын ажилчдын цалин 12,9%-иар нэмэгдэж, их, дээд сургуулийн багш нарын сарын дундаж цалин 28212,6 мянган рубль, дунд сургуулийн багш нар 13479,5 мянган рубль, шинжлэх ухааны

салбарын ажилчдын цалин 8%-иар нэмэгдэж, эрдэм шинжилгээний ахлах ажилтан 41111,1 мянган рубль болсон байна. Соёлын салбарын ажилчдын сарын дундаж цалин 24665 мянган рубль байна. ОХУ-д нийтдээ 14,5 сая төрийн албан хаагчид ажилладаг байна. Төрийн албан хаагчдын цалингийн шинэ тогтолцоо нь ажилчдын цалинг салбарын онцлог, ажилчдын мэргэжлийн зэрэг, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, цол, албан тушаал, ажилласан жил, ажил үүргээ чанартай, хариуцлагатай гүйцэтгэсэн байдал, ажлын хүнд, хортой нөхцөл, улсын нууцтай холбоотой ажил эрхэлдэг хүмүүс, илүү цагаар ажилладаг, уулын, говь, хээрийн, цөлийн бүсэд ажиллаж байгаа ажлын орчин зэргээс хамааран тогтмол нэмэгдэх коэффициентын журмаар олгохоор шинэчилсэн нь ажилчдын ажлын үр ашиг, бүтээмж, хувь хүний мэргэжлээрээ өсөн дээшлэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

2010 оны эхний хагас жилийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээс харахад хүн амын сарын цалингийн дундаж 20 мянга 144 рубль байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,5%-иар нэмэгдсэн буюу 17 мянга 928 рубль байсан байна. Түүнчлэн уул уурхай, нефть, хий, алт олборлож байгаа бүс нутгуудад сарын цалингийн дундаж үзүүлэлт өндөр байгаа бөгөөд 45 мянга гаруй рубль, харин хөдөө аж ахуйн бүс нутаг болох өмнөд бүс нутагт амьдралын өртөг доогуур байгаа бөгөөд сарын дундаж цалин 11 мянга орчим рубль байна.

2000 онд хүн амын амьжиргааны доод түвшинээс (ХААДТ) доогуур орлоготой ядуу хүмүүс хүн амын 29%-ийг эзэлж байв. Ядуурлыг бууруулах бодлого, засгийн газрын өргөн хүрээтэй хөтөлбөрүүдийн үр дүнд жил ирэх тусам ядуурлын түвшин буурч 2002 онд 24,6%, 2003 онд 20,3%, 2004 онд 17,6%, 2005 онд 17,7%, 2006 онд 15,2%, 2007 онд 13,4%, 2008 онд 13,1% болж тус тус буурсан үзүүлэлттэй байна. 2007 оны 12 сараас эхэлсэн санхүү зах зээлийн хямралын улмаас 2008 онд Оросын аж үйлдвэрийн салбарын өсөлт хүлээгдэж байснаас доогуур гарч, эрэлтийн хэмжээ буурч, ажилгүйдлийн түвшин өсөж 10 хувьд хүрсэн байв. Өнөөгийн байдлаар хямралын байдлаас гарч, хүн амын орлого нэмэгдэн, хэрэглэгчийн зардал өсөж, хүн амын хуримтлал нэмэгдэж байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэнээр 2010 онд ажилгүйчүүдийн дундаж тоо 5,4 сая хүн буюу хөдөлмөрийн чадвартай хүн амын 7,1%-ийг эзэлж байна.

ХААДТ-г тогтоох нь ОХУ-ын татвар, торгуулийн хэмжээ, засгийн газраас явуулж буй бодлогын үр дүнг хэмжих нэг үзүүлэлт гэж үздэг. Хүүхэд, өндөр настан, залуучууд зэрэг бүлгүүдийн хэрэглээ асар их ялгаатай байдгийг харгалзан үзэж ХААДТ-г нийт хүн ам, хөдөлмөрийн чадвартай хүн ам, хүүхэд, өндөр настан гэсэн ялгаатайгаар, улирал тус бүрээр тодорхойлдог онцлог талтай. Энэ нь бараа бүтээгдэхүүний өсөлт, хэрэглээнд гарч буй өөрчлөлтүүдийг цаг алдалгүй хүн амын

амьжиргааны доод түвшиндээ тусгах боломжийг олгож байдаг. 2010 оны III улирлын байдлаар нэг хүнд оногдох ХААДТ-г 5707 рубль, хөдөлмөрийн чадвартай хүн амын хувьд 6159 рубль, хүүхэд 5510 рубль, өндөр настануудад 4532 рублиэр Засгийн газраас тогтоож өгсөн байна.³ 2011 онд өндөр настаны амьжиргааны доод түвшиний хэмжээг 2010 онтой харьцуулахад 8,3%-иар буюу сард 6273 рубль болгон нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2013 онд 30%-д хүргэх төлөвлөгөөтэй байна.⁴ Өндөр настануудын тоо өнөөгийн байдлаар 30 сая байгаа бөгөөд энэ нь оросын нийт хүн амын 20%-ийг эзэлж байна. Жил ирэх тусам энэ тоо нэмэгдэж байдаг хэдий ч өндөр настануудад олгодог тэтгэврийн хэмжээг жил бүр тогтмол нэмэгдүүлсээр иржээ. Нийгмийн нэг чухал асуудал амжилттай шийдэгдсэн нь тэтгэврийн дундаж хэмжээ ХААДТ-г давсан явдал юм. 2010 оны 12-р сард тэтгэврийн дундаж хэмжээ 7600 рубль, түүний дотор өндөр насны тэтгэвэр 8200 рубль байв. Энэ нь 2009 оны мөн үетэй харьцуулахад 1,45 дахин илүү байгаа юм.

Ийнхүү Орос улс хүн төвтэй нийгмийн хөгжлийн олон асуудлыг амжилттай шийдэрлэж байна. Хүн амын өсөлт, бүтэц, байршил болон түүнд гарч буй өөрчлөлтүүд, үйлдвэрлэл ба хэрэглээний тогтвортой бус хандлага, шинэ техник, технологийн дэвшил, хүрээлэн буй орчины бохирдол зэрэг хүчин зүйлсүүдийг харилцан уялдаатай авч үзэх шаардлага тулгарч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Государственный доклад “О положении детей в Российской Федерации”. М. 2002. стр 120.
2. Т.А.Голикова. Министр здравоохранения и социального развития РФ. Об итогах работы Министерства здравоохранения и социального развития Российской Федерации в 2010 году и задачах на 2011 год.
3. Об установлении величины прожиточного минимума на душу населения и по основным социально-демографическим группам населения в целом по Российской Федерации за III квартал 2010 г. // http://www.minzdravsoc.ru/docs/doc_projects/476
4. “Преодоление нищенства” Депутаты Мосгордумы утвердили стандарты жизни для себя и пенсионеров. //Время. №198, 28 октября 2010.